

2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2022.01.03

Дугаар 14

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелүүлэх хугацаа	Биелэлт
1	Булган сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх арга хэмжээ авах, тус сумын амьжиргааны түвшин доогуур айл, өрхүүдэд олгож буй хүнсний талон олголтын байдалд хяналт шалгалт хийх	ЭМГ-ын дарга Н.Сакен ХХҮГ-ын дарга А.Галия	I/06	1. ЭМГ-аас биелэлт ирүүлээгүй. 2. Аймгийн ХХҮГ-аас биелэлтийг хугацаанд нь дараах байдлаар ирүүлсэн. Үүнд: Булган сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхүүдэд ХХҮГ-ын Нийгмийн халамжийн хэлтсээс дотоод хяналт, шалгалт хийсэн. 2021 оны хувьд Булган сумд нийт 110 өрх хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байсан. 2021 оны 12 дугаар сард Булган сумын амьжиргааны түвшин дээшилсэн, малын тоо өссөн шалтгаанаар 19 өрхийн 137 иргэний, 2022 оны 1 дүгээр сард 1 өрхийн 6 иргэний хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авах эрхийг түдгэлзүүлсэн. Салбарын яамнаас дэвшүүлж байгаа Халамжаас хөдөлмөрт зорилгын хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс татгалзах ажлыг зохион байгуулж, ХНХСайдын 2021 оны 06 сарын 25-ны өдрийн А/103 тушаалаар баталсан Хүнсний эрхийн бичиг олгох журмын дагуу аймгийн хэмжээнд 558 өрхийн 3207 иргэний эрхийг түдгэлзүүлсэн болно.
2	Алтай, Булган, Дэлүүн сумдын газрын даамал, хөдөлмөр, халамж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, нийгмийн даатгалын байцаагч нарын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх. Үйл ажиллагааг нь жигдрүүлэх	ХХҮГ-ын дарга А.Галия ГХБХБГ-ын дарга К.Болат НДХ-н дарга М.Армия	I/06	ХХҮГ: Булган сум хариуцсан мэргэжилтэн Ж.Бауыржан нь 2021.12.01-ний өдөр шинээр томилогдсон, Дэлүүн сум хариуцсан мэргэжилтэн М.Тотыхус нь жирэмсний амаржсаны чөлөөтэй байгаа ба оронд нь түр хугацаагаар хүн ажиллаж байна. Мэргэжилтнүүдэд ажил цалгардуулахгүй, төрийн ажлыг иргэдэд түргэн, шуурхай хүргэж ажиллах талаар чиглэл хүргүүлээ. Алтай сумын мэргэжилтэн С.Мөнхтулгын асуудлаар нутгийн иргэд болон Алтай сумын удирдлагаас ирүүлсэн гомдлын дагуу байгууллагын дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлөөр хэлэлцэн С.Мөнхтулгад Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтаар сануулах арга хэмжээ авч хариуцлага

				тооцохоор шийдвэрлэсэн болно. ГХБХБГ: Алтай, Булган, Дэлүүн сумдын газрын даамлуудын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийж ажлыг нь дүгнэсэн. НДХ-аас биелэлт ирүүлээгүй.
3	Сул орон тооны захиалга, жагсаалтыг ТАСЗ-д яаралтай ирүүлэх	Нийт байгууллага, агентлагууд	I/06	Сул орон тооны захиалгын талаарх үүргийн биелэлт, холбогдох тайлбар мэдээллийг МХГ, ГБХЗХГ, МЭГ, ТХ, БОАЖГ, ОНӨГ, ОБГ, ХХААГ-аас ирүүлсэн. Бусад байгууллагууд биелэлт ирүүлээгүй байна.
4	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн өөрчлөх	Нийт байгууллага, агентлагууд	I/06	ГХБХБГ, ОНӨГ-аас: Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу байгууллагын дотоод журмыг баталж, үйлчилгээний ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг шинэчиллээ. МХГ-аас: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажилчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлж өөрчлөх ажлын хэсэг томилогдож чиг үүргийн шинжилгээ хийж байна. ГБХЗХГ, МЭГ, ТХ, ОБГ ХХААГ-аас: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн өөрчлөх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж байна. УЦУОШГ, Статистикийн хэлтэсээс: ЦУОШГазар, Статистикийн хорооноос хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдэн ирсний дараа салбарын дотоод журмыг баталж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн өөрчлөхөөр бэлтгэл ажлаа хангасан. Бусад байгууллагууд биелэлт ирүүлээгүй байна.
5	2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө бүх нээлттэй тендерүүдийг зарлах	ХОХБТХ-н дарга Х.Анар ГХБХБГ-ын дарга К.Болат ОНӨГ-ын дарга Т.Назым	I/06	ГХБХБГ-аас: Улсын хөрөнгө оруулалттай шинээр хийх 8 объектын зураг төсвийн ажлын зураг хийх компаниудтай гэрээ хийх ажлыг зохион байгуулж байна. ОНӨГ-аас: 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдөр 01/459 албан тоотоор Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 01/460 албан тоотоор Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад тус тус зураг төсөв, ажлын даалгавар техник тодорхойлолтуудыг 2022 оны 01 дүгээр сарын 03-ний

				дотор яаралтай ирүүлэх талаар хүсэлт тавьсан болно. 2022 оны 01 дүгээр сарын 05-ний өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд Аймгийн Засаг дарга болон бусад холбогдох дарга нар, мэргэжилтнүүдэд 01 дүгээр сарын 30-ний дотор зураг төсөв, ажлын даалгаврыг Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг үүрэг болгосон.
6	Коронавируст халдварын эсрэг вакцины 3 дугаар тунгийн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлж, 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл нийт хамрагдалтыг 60 хувьд хүргэх,	Аймгийн ЭМГ-ын дарга Н.Сакен Өлгий сумын ЗД Д.Есболат	I/06	Ирүүлээгүй
7	Харьяа багийнхаа иргэдийг Коронавируст халдварын эсрэг вакцины 3 дугаар тунд хангалтгүй буюу 50 хувиас доош хамруулсан ЗД нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх арга хэмжээ авах	Өлгий сумын ЗД Д.Есболат	I/06	Ирүүлээгүй
8	Цагаан сарын баярыг тохиолдуулан Урианхай, Тува, Буриад иргэдийн ажил амьдрал, соёлын талаар мэдээлэл бэлдэх, мэндчилгээ дэвшүүлэх	ОНОНРТ-ын дарга Н.Оспан	I/06	Ирүүлээгүй
9	ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан хаагчдын жагсаалтыг аймгийн ЗДТГ-т ирүүлэх	Нийт байгууллага, агентлагууд	I/06	ГХБХБГ, ГБХЗХГ, БОАЖГ, ОНӨГ, ХХААГ, УЦУОШГ-аас: ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан хаагчдын жагсаалтыг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. МХГ-аас: ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан хаагчдын нэрсийн жагсаалтыг МХЕГ-ын Тамгын газарт 2022.01.03-ны 01/02 албан тоотоор хүргүүлсэн. Аймгийн ЗДТГ-т нэрсийн жагсаалт өгдөггүй. МЭГ, Татварын хэлтэс, ОБГ: Жагсаалтыг МЭЕГ, ТЕГ, ОБЕГ-т хүргүүлсэн гэх биелэлтийг ирүүлжээ. Бусад байгууллагууд ирүүлээгүй байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР